



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн санхүүгийн аудитын тайлан.

ОРОН НУТГИЙН 2016 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



АГУУЛГА

Зөвлөмж:.....
 Õïéáíãäî õ ääéäóóëëääûí ñàíàë.....
 Õääñõäèò.....

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АУЭХС ТӨХК	Алтай улиастай эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компани
МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ААГ	Аймгийн аудитын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХО	Хөрөнгө оруулалт
ААН	Аж ахуйн нэгж
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
СХС	Сум хөгжүүлэх сан
СЯ	Сангийн яам
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
АББ	Албан бус боловсрол
МХС	Мал хамгаалах сан
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бэрхшээл

Аудит хийх үндэслэл үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу, Монгол Улсын Ерөнхий аудиторт Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

Аймаг орон нутгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж дүгнэлт гарган, Үндэсний аудитын газарт хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ.

1. Нэгдсэн төсвийн орлого зарлагын төлөвлөлтийн үндэслэл
2. Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл
3. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл, үр дүнгийн үзүүлэлт

Хамарсан хүрээ

Аудитаар аймгийн орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа бусад баримт материалд тулгуурлан аудит хийлээ.

Аймгийн аудитын газар нь Говь-Алтай аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийхээс өмнө Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу бүх шатны төсвийн захирагч болон орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

Санхүүгийн тайланг санхүүгийн аудитын арга зүйг ашиглан төсвийн орлого болон зардлын гүйлгээнд дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, баримт материалыг тулган баталгаажуулах, дахин тооцоолох, чиг үүргийн шинжилгээний дүнд байгууллага хоорондын ажил, үүргийн давхардлыг арилган, зохион байгуулж, бүтэц орон тоог үндэслэлтэй тогтоох боломжийг судлах, төсөвт байгууллагуудын орон тоо, төсвийн зардлын ачааллыг багасгах арга замыг судлах зэрэг арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын хяналт тавьж стандартыг хангуулан, Ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитор Г.Цэцэгмаа, шинжээч Г.Энхдэлгэр нар 2017 оны 04 дүгээр сарын 05-наас 04 дүгээр сарын 25-ныг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

ОРШИЛ

Монгол улсын 2016 оны төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн орлого, зарлагад дараах зарчмуудыг баримталсан байна. Үүнд:

- ✚ Төсвийн орлогыг бодитойгоор тооцох
- ✚ Бүх шатны төсөвт хэмнэлтийн горимыг мөрдөж, тэвчиж болох урсгал зардлыг бууруулах, нийт зардлын өсөлтийг хязгаарлах
- ✚ Төрийн байгууллагуудын бүтцийг цомхон, чиг үүргийн давхардалгүй зохион байгуулах, зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх замаар бүтээмжийг нэмэгдүүлэх, урсгал зардлыг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх
- ✚ Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн аливаа хөрөнгө оруулалтын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалттай холбоотой гарах урсгал зардлыг орон нутаг бие даан санхүүжүүлэх зарчимд шилжих, ингэснээр орон нутгийн өмчийн ашиглалт, хөрөнгө оруулалтыг оновчтой, үр ашигтай болгох зэргийг тусгажээ.

Говь-Алтай аймгийн орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт 98.6 хувийн, нийт зарлага 91.6 хувийн гүйцэтгэлтэй, улсын төсвөөс 9,416.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгээр 32,237.0 сая төгрөгийн санхүүжилт авсан.

Аймгийн 2016 оны орлого зарлагын төлөвлөлтийн тэнцлийг авч үзвэл дараах байдалтай байна.

Орон нутгийн нэгдсэн төсөв

Хүснэгт-1	сая.төгрөг
Орон нутгийн орлого, санхүүгийн дэмжлэгийн дүн	57,593.0
Орон нутгийн орлого	6,348.9
Төсөвт байгууллагын өөрийн орлого	139.6
Санхүүгийн дэмжлэг / улсаас/	9,416.7
ОНХС-аас авах шилжүүлэг	5,693.7
Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт/ сум хөгжүүлэх сан/	1,812.2
2015 оны төсвийн үлдэгдлээс /ОНХС, МХС, ТЭДС/	369.2
Шилжих үлдэгдлээс санхүүжих / ОНО-ийн үлдэгдлээс/	1,575.7
Тусгай зориулалтын шилжүүлэг	32,237.0
Орон нутгийн зарлагын дүн	57593.0
Сумын удирдлагын дүн	6,642.5
Аймгийн удирдлагын дүн	3,797.3
Тусгай зориулалтын шилжүүлэг	32,303.8
Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт/ сум хөгжүүлэх сан/	1,812.2
Халамжийн сан	5,013.3
Тусгай санд зарцуулах / МХС, ТЭДС/	69.5
ОНХС-нд зарцуулах	6,177.7
ОНО-нд зарцуулах	1,776.7


Говь-Алтай аймгийн төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд төсөв, татварын орлогыг тогтвортой байлгах, төсвийн санхүүжилтийг найдвартай эх үүсвэрээр хангахын тулд төсвийн төсөлд орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөх, төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлах, төсвийн орлогын тогтвортой бааз суурийг бий болгох, татвар хураалтыг эрчимжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

Тусгай зориулалтын шилжүүлэг ба ОНХС, СХС, МХС, ТЭДС-гийн дүнг хасч тооцвол орон нутгийн төсвийн тэнцэл дараах байдалтай байна.

Орон нутгийн төсөв

Хүснэгт-2	сая.төгрөг
Орон нутгийн орлого, санхүүгийн дэмжлэгийн дүн	17,229.8
Орон нутгийн орлого	6,348.9
Төсөвт байгууллагын өөрийн орлого	43.5
Санхүүгийн дэмжлэг / улсаас/	9,416.7
Шилжих үлдэгдлээс санхүүжих / ОНО-ийн үлдэгдлээс/	1,420.7
Орон нутгийн зарлагын дүн	17,229.8
Сумын удирдлагын дүн	6,642.5
Аймгийн удирдлагын дүн	3,797.3
Халамжийн сан	5,013.3
ОНХО-нд зарцуулах	1,776.7

2016 онд нийт орлогын 54.6 хувийг улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, 36.8 хувь нь орон нутгийн төсвийн орлого, 0.2 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого эзэлж байна. Харин нийт төсвийн хувьд 1,944.6 сая төгрөгийн төсвийн дутагдлыг шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.



Орон нутгийн төсвийн бүтэц, урсгал орлого зардлын харьцааг судалж үзэхэд аймгийн орон нутгийн нийт орлогод орон нутгийн төсвийн орлогын эзлэх хувь хэмжээг сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулж үзэхэд 2014 оноос 2015, 2016 онд өссөн үзүүлэлттэй байна.



I Бүлэг. Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл

Төсвийн төлөвлөлтийг бодит тоон судалгаанд үндэслэн, үнэн зөв оновчтой төлөвлөх шаардлагатай байна.

Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх зарчмуудыг баримтална. Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2016 оны төсөв батлах тухай” 13 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсөв захирагчдын төсвийн жилд зарцуулах зардлын дүнг 53,659.6 сая төгрөгөөр, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгийн орон нутгийн төсвийн орлогын дүн 5,369.9 сая төгрөг, төсвийн ерөнхийлөн захирагч, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 9,600.2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд улсын төсвөөс авах орлогын шилжүүлгийг 6,569.8 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн нийт дүнг 32,119.7 сая төгрөгөөр баталсан байна.

Мөн сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 5,670.7 сая төгрөг, сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 3,941.8 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын хэмжээг 1,048.4 сая төгрөгөөр тус тус тогтоожээ.

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2¹ дахь заалтын дагуу сумдын ИТХ тухайн сумын төсвийг батлахдаа аймгийн ИТХ-аар баталсан төсвийг 3,933.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Төсвийн орлого зарлагын төлөвлөлтийг Төсвийн тухай хууль болон ЗГ-ын тогтоол, Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу төлөвлөсөн эсэхийг авч үзвэл:

Орон нутгийн орлогын төлөвлөлтийн талаар:

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс нь аймгийн харьяа 18 сум 2 тосгоноос төсвийн орлогын төсөлд өгөх саналыг авч тухайн сумдын өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулж мөн Орон нутгийн өмчийн алба, Байгаль орчны газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, аймгийн Шүүх, Цагдаагийн газар, Татварын хэлтсийн мэдээлэлд үндэслэж орон нутгийн орлогын саналыг Сангийн яамд явуулдаг байна.

¹ Тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх

Аймгийн төсвийн 2016 оны суурь орлогыг УИХ-аас анх 5,252.4 сая төгрөгөөр хянан баталсны дагуу аймгийн ИТХ өөрийн онцлог байдалтай уялдуулан хуулиар эрх олгогдсон зарим татварын хувь хэмжээг өсгөснөөс татварын орлогыг 410.9 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 312.0 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 20.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж нийт орлогыг 6,392.6 сая төгрөг болгон баталсан байна.

2016 оны орон нутгийн төсвийн орлого /сая.төг/

Үзүүлэлт	Санал		Сангийн яамнаас хянасан		УИХ-аас батлагдсан		ИТХ-аар батлагдсан	
	Нийт орлого	Суурь орлого	Нийт орлого	Суурь орлого	Нийт орлого	Суурь орлого	анх батлагдсан	тодотгосон
Татварын орлого	4,585.4	4,636.4	4,913.5	4,964.5	4,839.0	4,889.9	5,249.9	5,633.2
Татварын бус орлого	328.0	328.0	413.4	413.4	413.4	413.4	725.4	738.6
Хөрөнгийн орлого							20.8	20.8
НИЙТ ОРЛОГО	4,913.4	4,964.4	5,326.9	5,377.8	5,252.4	5,303.3	5,996.2	6,392.6

Дээрх судалгаанаас үзэхэд орон нутгийн төсвийн орлогын саналыг Сангийн яам хянаж, аймгийн ИТХ-аар батлахдаа анх өгсөн саналаас 1,479.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.Хавсралт-1

УИХ-аас баталсан дүнгээс нэмэгдүүлсэн баталсан орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

- ✚ Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 98.5 сая төгрөгөөр
- ✚ Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан, амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн орлогыг 88.7 сая төгрөгөөр
- ✚ Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 37.7 сая төгрөгөөр
- ✚ Нэр заагдаагүй бусад орлогыг 279.5 сая төгрөгөөр
- ✚ Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 161.3 сая төгрөгөөр
- ✚ Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 34.5 сая төгрөгөөр
- ✚ Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг 46.3 сая төгрөгөөр
- ✚ Газрын төлбөрийн орлогыг 120.5 сая төгрөгөөр
- ✚ Өмч хувьчлалын орлогыг 20.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталжээ.

Харин үйл ажиллагааны орлогыг 13.9 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 3.1 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Орон нутгийн орлогын төлөвлөлт үндэслэлтэй байгаа эсэхэд дүгнэлт өгөхийн тулд орлогын 2014-2016 оны 3 жилийн төлөвлөлт, гүйцэтгэлд судалгаа хийж үзлээ. Орон нутгийн орлогыг нийт дүнгээр 2014 онд төлөвлөгөөнөөс 695.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч 2015 онд 541.6 сая төгрөгөөр, 2016 онд 86.7 сая төгрөгөөр тасалсан. Энэ судалгаанаас бид 2-3 жил дараалан тасарсан орлогыг харууллаа. Хавсралт-2

Тасарсан орлогын судалгаа /сая.төгрөг/

Орлогын нэр төрөл	2014 он	2015 он	2016 он
Хувь хүний орлогын албан татвар		(135.1)	
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого		(251.6)	(13.9)
Үйл ажиллагааны орлого	(9.5)		(3.1)
Хөрөнгийн орлого		(13.0)	
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	(5.1)	(111.2)	(104.6)
Бууны албан татвар	(1.6)	(0.1)	(27.2)
Газрын төлбөр		(100.5)	
Ойн нөөц ашигласны төлбөр		(0.6)	
Ус рашаан нөөц ашигласны төлбөр	(74.6)	(47.3)	
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр		(0.4)	
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	(9.4)	(5.9)	
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	(38.8)	(34.1)	(22.2)
Бусад орлого	(226.3)	(318.9)	(155.7)
Түрээсийн орлого	(1.0)	(0.7)	
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого			(12.3)

Судалгаанаас үзэхэд үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, бусад орлого нь 2014, 2015, 2016 онуудад тасарсан байхад цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 2015, 2016 онуудад жил дараалан тасарчээ. Харин 2016 оны тухайд үйл ажиллагааны орлого, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого тасарсан байна. Бид аудитаар Татварын хэлтсийн орон нутгийн орлогын өр авлагын судалгааг 2016 оны тасарсан, давсан орлогын дүнтэй харьцуулсан судалгаа хийсэн. Хавсралт-3

Харьцуулсан судалгаа /сая.төгрөг/

Орлогын нэр төрөл	2016 оны тасарсан орлого	Татварын хэлтсийн тайлангаарх үлдэгдэл	
		Дутуу	Илүү
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	(13.9)	501.3	32.3
Үйл ажиллагааны орлого	(3.1)		0.1
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	(104.6)	126.8	21.8
Бууны албан татвар	(27.2)	11.4	0.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	(22.2)	1.3	0.1
Бусад орлого	(155.7)		
Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого	(12.3)		

Дээрх судалгаанаас үзэхэд цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогын төлөвлөгөө тасрах шалтгаан нь татвар хураалтын үйл ажиллагаатай холбоотой байгаа бол үйл ажиллагааны орлого, бууны албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого нь төлөвлөлттэй шууд холбоотой байна.Тухайлбал:

- Бууны албан татварын хувьд галт зэвсэг эзэмшигч нь харьяа цагдаагийн байгууллагад анх бүртгүүлэх, шилжилт хөдөлгөөнийг хийлгэх хасуулах харилцааг бүртгүүлэхээр байгаа хэдий ч энэ процесс хийгдэхгүй, иргэдийн гар дээр байгаа галт

зэвсгийн мэдээлэл бодитой байхгүйгээс болж төлөвлөлтийг үндэслэлгүй төлөвлөж байна.

- Ул хөдлөх хөрөнгийн албан татварын хувьд “Алтайн хүдэр”ХХК 2015 онд 102.0 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн албан татварыг төлөөгүйгээс орлого тасарсан бол 2016 онд мөн 107.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг тасалсан байна.

Бусад орлогын талаар:

“УИХ-ын гишүүдэд 2009-2011 онуудад хуваарилагдсан хөрөнгөөр орон нутагт хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын үр дүн”-д 2012 онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор иргэд, хоршоо, аж ахуйн нэгжид олгосон зээлийн эргэн төлүүлээгүй 1,008.7 сая төгрөгийг төлүүлэх албан шаардлага хүргүүлсний дагуу иргэд, хоршоо, аж ахуйн нэгжүүдтэй зөвшилцөн график гаргуулан эргүүлэн төлүүлэхээр шийдвэр гарсан байна. Зээлийн эргэн төлөлтийг дараах хүснэгтээр харуулбал:

Зээлийн эргэн төлөлт /сая төгрөг/

Огноо	Эргэн төлөгдөх хуваарь	Хасагдсан дүн				Төлөгдөөгүй үлдэгдэл
		Төлөгдсөн дүн	ОНӨА-д хөрөнгө орлого авсан	ШШГ-ийн урамшуулалд өгөхөөр тооцсон	Нийт хасагдсан дүн	
2012 он	60.2	235.9		14.1	596.0	412.7
2013 он	443.3	214.6				
2014 он	505.2	32.9				
2015 он		43.8	29.4			
2016 он		23.3				
2017 он		2.0				
ДҮН	1,008.7	552.5	29.4	14.1	596.0	412.7

Судалгаанаас харахад 2012, 2013 онуудад зээлийн эргэн төлөлт сайн байхад 2014 оноос хойш маш хангалтгүй байгааг илэрхийлж байна. Хавсралт-4

Мөн 2012 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар жижиг дунд үйлдвэрлэл, эрчимжсэн газар тариалан, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйг дэмжих зорилгоор хоршоо, иргэдэд буцаан төлөгдөх нөхцөлтэйгээр дахин зээл олгосноос 2013 оны байдлаар 405.1 сая төгрөгийг төлүүлээгүй байсан.Зээлийн эргэн төлөлтийг харуулья.

Зээлийн эргэн төлөлт /сая төгрөг/

Огноо	Олгосон зээл	Төлөгдсөн дүн	ШШГ-ийн урамшуулалд өгөхөөр тооцсон	Нийт хасагдсан дүн	Төлөгдөөгүй үлдэгдэл
2012 он	405.1		19.8	66.3	338.8
2013 он					
2014 он					
2015 он		20.7			
2016 он		22.3			
2017 он		3.5			
ДҮН	405.1	46.5	19.8	66.3	338.8

Дээрх зээлүүдээс эргэн төлөгдөх хугацаа дууссан боловч одоогийн байдлаар 62 иргэн, аж ахуйн нэгж, хоршоотой холбоотой нийт 751.4 сая төгрөгийн зээлийг төлүүлээгүй

нь бусад орлогын төлөвлөгөө тасрах үндсэн шалтгаан болж байгаа тул зээлийг төлүүлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

Нийт төлөгдөөгүй 751.4 сая төгрөгийн зээлийн үлдэгдлээс 607.3 сая төгрөгийн зээлийг шүүхийн шийдвэр гаргуулж Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаар барагдуулах арга хэмжээ авч байгаа бол 11 зээлдэгчийн 144.1 сая төгрөгийн зээлийг төлүүлэхээр ямарч арга хэмжээ аваагүй байгааг төсвийн ерөнхийлөн захирагчийн анхааралд хандуулж байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын талаар:

2014 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Есөнбулаг сумын Засаг дарга Ж.Ганбат, АУЭХС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Чинзориг нарын баталсан "Хамтран ажиллах гэрээ"-ний 2 дугаар зүйлийн 2.2²-д заасны дагуу Алтай хотын айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг АУЭХС ТӨХК гүйцэтгэж, орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр заасан.

Есөнбулаг сумын ЗДТГ, АУЭХС ТӨХК-тай 2016 оны хог хаягдлын үйлчилгээний хураамжийн тооцоо хийхэд:

АУЭХС ТӨХК-ийн оруулсан орлого	69.7 сая
Орлогоос суутган үлдсэн ажлын хөлс /25 хувь/	17.4 сая
Орон нутгийн орлогод төвлөрүүлэх дүн	52.3 сая
Төвлөрүүлсэн хогны хураамжийн дүн	50.6 сая
Дутуу төвлөрүүлсэн мөнгөн дүн	1.7 сая

Дутуу төвлөрүүлсэн 1.7 сая төгрөгийн 0.9 сая төгрөг нь тооцоо нийлсэн актаар баталгаажсан бөгөөд байгуулсан гэрээний дагуу орон нутгийн орлогод төвлөрүүлэх орлогоос 0.6 сая төгрөгийг орлого бууруулж программын үнэ төлүүлсэн, 0.2 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

"Хамтран ажиллах гэрээ"-ний 2 дугаар зүйлийн 2.1-д "Гүйцэтгэгч талд хураан төвлөрүүлсэн хог хаягдал гаргасны төлбөр буюу хог хаягдлын үйлчилгээний хураамжийн 25%-ийг ажлын хөлс болгон олгоно" гэж зааснаар 2016 онд 17.4 сая төгрөгийг хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоос суутган тооцжээ. Гэвч хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг төлөвлөхдөө айл өрхийн тоог хогны хураамжид үржүүлж тооцсон байгаа тул суутган тооцсон 17.4 сая төгрөг нь орлого тасрах бүрэн үндэслэл болсон байна.

Иймд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг гэрээний дагуу бүрэн төвлөрүүлж, АУЭХС ТӨХК-д олгох ажлын хөлсийг урсгал зардалд төлөвлөн олгож байх нь зүйтэй.

² Гүйцэтгэгч тал сар бүрийн 15-ны өдрөөр тасалбар болгон тухайн сарын төвлөрсөн хог хаягдал гаргасны төлбөр буюу хог хаягдлын үйлчилгээний төлбөрийг дараа сарын 10-ны дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн сан банкин дахь 050100910 тоот Есөнбулаг сумын татварын орлого дансанд шилжүүлж, сар бүрийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.

Зардал төлөвлөлтийн талаар:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1³ дэх заалтанд заасан цаглабарын дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарыг боловсруулж Сангийн яамд хүргүүлэхээр заасан.

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны төсвийн саналыг нэгтгэн яаманд хүргүүлсэн төсөв болон баталсан төсөвтэй харьцуулахад дараах байдалтай байна. Хавсралт-5

Байгууллагын төсвийн төсөл, батлагдсан төсөв /сая.төг/

Үзүүлэлт	Зөрүү					
	Байгууллагын санал	Сангийн яамд хүргүүлсэн	Сангийн яам хянасан	Батлагдсан төсөв	Байгууллагын санал Сангийн яамд хянасан	Байгууллагын санал батлагдсан төсвийн
	1	2	3	4	*1-2	*1-3
Аймгийн засаг дарга	25,660.9	25,660.9	15,291.4	21,540.0	(10,369.5)	(4,120.9)
Боловсрол Шинжлэх ухааны сайд	32,065.9	32,065.9	32,065.9	27,207.3	-	(4,858.6)
Барилга хот байгуулалтын яам	335.9	335.9	182.0	184.5	(153.9)	(151.4)
Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайд	380.1	380.1	340.1	340.1	(40.0)	(40.0)
Эрүүл мэндийн сайд	4,387.7	4,387.7	4,387.7	4,387.8	-	0.1
НИЙТ ДҮН	62,830.4	62,830.4	52,267.0	53,659.7	(10,563.4)	(9,170.7)

Дээрх судалгаанаас үзэхэд төсөвт байгууллагуудын төсвийн мэргэжилтэн нь нэгж байгууллагуудын төсвийн саналыг нэгтгэн давтан тооцоолж үзээд Сангийн яаманд хүргүүлдэг боловч Сангийн яамнаас голцуу танагдаж ирдэг байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын төсвийн төслөөс Сангийн яам хянасан дүн нь 10,563.4 сая төгрөгөөр бага, батлагдсан дүн нь байгууллагын саналаас 9,170.8 сая төгрөгөөр дутуу байгаа нь нэг талаас нэгж байгууллагууд төсвийн төслөө үндэслэлгүй хийж, ихээхэн хэмжээгээр төсөв авах сонирхолтой байгааг харуулж байгаа бол нөгөө талаас Сангийн яам төсвийн саналыг харгалзан үзэлгүйгээр өмнөх жилийн төсвийн төлөвлөгөө гүйцэтгэлтэй уялдуулан олгодогтой холбоотой байна.

Аймгийн 2016 оны төсвийг анх аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 13 дугаар тогтоолоор 53,659.6 сая төгрөгөөр баталсан ба аймгийн ИТХ-ын 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 55,149.5 сая төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 54,473.9 сая төгрөгөөр тус тодотгосон байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 05-ны өдрийн 09 дугаар тогтоолоор төсвийн эх үүсвэрийг дараах байдлаар баталсан: Үүнд:

³ Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх

- ✚ Аймгийн татварын болон татварын бус орлогыг 5,544.5 сая төгрөг
- ✚ Орон нутгийн төсвийн байгууллагын өөрийн орлогыг 28.6 сая төгрөгөөр
- ✚ ТЕЗ-ийн улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 9,416.6 сая төгрөгөөр
- ✚ Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 32,237.1 сая төгрөгөөр
- ✚ Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлогыг 66.8 сая төгрөгөөр
- ✚ Аймгийн шилжих үлдэгдлээс санхүүжигдэх дүнг 1,417.3 сая төгрөгөөр
- ✚ Тусгай сангийн шилжих үлдэгдлээс 69.4 сая төгрөг
- ✚ Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг 5,693.6 сая төгрөгөөр нийт 54,473.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэрээр аймгийн төсвөөс 2016 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг баталсан байна.

Орон нутгийн нэгдсэн төсвийн тэнцэл

Үзүүлэлт	анх батлагдсан 2015.12.04 №13	2016 он тодотгол-1 2016.06.07 № 01	тодотгол-2 2016.12.05 №09
ИТХ-ын огноо шийдвэр			
Нийт орлого ба тусламжийн дүн	53,659.6	53,595.9	52,920.4
Урсгал орлого	5,369.9	5,373.1	5,573.1
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	53,659.6	55,149.5	54,473.9
Урсгал зардал	47,089.8	48,579.8	48,780.2
Урсгал тэнцэл	(41,719.9)	(43,206.7)	(43,207.1)
Нийт тэнцэл	0	(1,553.6)	(1,553.5)
Нийт тэнцлийн алдагдлыг Санхүүжүүлэх эх үүсвэр			
Өмнөх оны үлдэглээс	0	1,486.8	1,486.7
Өөрийн орлого	66.8	66.8	66.8
Урсгал тэнцлийн алдагдлыг Санхүүжүүлэх эх үүсвэр:	41,719.9	43,206.7	43,207.1
Тусгай зориулалтын шилжүүлгээс	32,052.9	32,052.9	32,303.7
Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	9,600.2	9,600.2	9,416.6
Өмнөх оны үлдэглээс	0	1,486.8	1,486.7
Өөрийн орлого	66.8	66.8	66.8

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 05-ны өдрийн 09 дугаар тогтоолоор орон нутгийн 2016 оны төсвийн нийт орлогыг 52,920.4 сая төгрөг, нийт зардлыг 54,473.9 сая төгрөг, нийт тэнцлийг 1,553.5 сая төгрөгөөр алдагдалтай байхаар тооцож, уг алдагдлыг өмнөх оны үлдэглээс 1,486.7 сая төгрөгийг, өөрийн орлогоор 66.8 сая төгрөгийн санхүүжүүлэхээр тооцож баталжээ.

Төсвийн төлөвлөлтийн үндэслэл

Аудитаар орон нутгийн засаг захиргаа, Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Барилга хот байгуулалтын сайдын ангилалаар төсөвт байгууллагуудын төсвийн төлөвлөлтөнд хэсэгчилсэн судалгаа хийж үзлээ. Судалгаанд цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ, цэвэр бохир ус, түлш халаалт, гэрэл цахилгаан, хоол, үдийн цайны зардлыг сонгон авч төлөвлөлтийг гүйцэтгэлтэй болон татан төвлөрүүлсэн санхүүжилттэй харьцуулж үзлээ.Хавсралт-6

Судалгаагаар тайлант онд төсөвт байгууллагууд 26,259.7 сая төгрөгийн цалингийн, 2,925.3 сая төгрөгийн НДШ-ийн төсөвтэй ажилласнаас үндсэн цалин, нэмэгдэл цалин, гэрээт ажилчдын цалин, ЗГ-ын 393, 150-р тогтоолын улирлын үр дүнгийн урамшуулал зэрэгт

нийт 25,140.3 сая төгрөгийн цалинг олгож, 2,780.4 сая төгрөгийн НДШ-ийн зардал гарган, 1,264.3 сая төгрөгийн бодит бус хэмнэлттэй ажиллалсан. Гэрэл цахилгааны зардлыг 54.3 сая төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 81.7 сая төгрөгөөр, цэвэр бохир усны зардлыг 15.2 сая төгрөгөөр, хоол, үдийн цайны зардлыг 125.8 сая төгрөгөөр хэмнэсэн нь бодит бус хэмнэлт байна. Учир нь 2016 онд дараах байгууллагууд нийт 1,759.3 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байгаагаас харахад төсвийг үндэслэлгүйгээр илүү төлөвлөж байгааг илэрхийлж байна.

Төсвийн хэмнэлтийг нэгтгэсэн судалгаа /сая. төгрөг/

№	Байгууллагын нэр	Бодит бус хэмнэлт				Татан төвлөрүүлсэн мөнгөн дүн
		Цалин хөлс, НДШ	Тогтмол зардал	Хоол, үдийн цай	нийт бодит бус хэмнэлт	
1	Аймгийн засаг дарга	99.1	56.6	-	155.7	281.5
2	Барилга хот байгуулалтын яам	2.4	1.9	-	4.3	6.7
3	Боловсрол Шинжлэх ухааны сайд	1,133.9	77.6	119.7	1,331.2	1,389.8
4	Эрүүл мэндийн сайд	28.90	15.10	6.10	50.1	81.30
	Нийт дүн	1,264.3	151.2	125.8	1,541.3	1,759.3

Сургуулийн өмнөх болон бага дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг 2016 оны тайланд хугацаанд Засгийн газрын 2012 оны 94 дүгээр тогтоол, 2016 оны 242 дугаар тогтоолыг мөрдөн багш нарын цалин, ажил олгогчоос төлөх НДШ, бусад хувьсах зардлыг тооцож төлөвлөхөөр заасан байна.

Дээрх судалгаанаас үзэхэд бидний сонгож авсан зардлуудаас Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын багцад хамаарах байгууллагууд цалингийн зардлыг 1,133.9 сая төгрөгөөр, тогтмол зардлыг 77.6 сая төгрөгөөр, хоол, үдийн цайны зардлыг 119.7 сая төгрөгөөр хэмнэсэн байгаа нь бодит бус хэмнэлт бөгөөд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг баримтлахгүйгээр төсвийг үндэслэлгүйгээр илүү баталж өгснөөр 1,389.8 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байгааг харуулж байна.

II Бүлэг. Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 86.7 сая төгрөгөөр тасалжээ.

Аймгийн 2016 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг анх аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ны 13 дугаар тогтоолоор 5,369.9 сая төгрөгөөр баталсан ба аймгийн ИТХ-ын 2016 оны 06 дугаар сарын 07-ны 01 дүгээр тогтоолоор 5,373.1 сая төгрөгөөр, 2016 оны 12 дугаар сарын 05-ны 09 дүгээр тогтоолоор 5,573.1 сая төгрөгөөр тус тодотгосон байна.

Орон нутгийн төсвийн орлогыг 2016 онд аймаг, сумдын нийт хэмжээнд 6,421.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс 6,335.2 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 98.6 хувиар биелүүлэн 86.7 сая төгрөгөөр тасарсан байна. Хавсралт-7

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт

/сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлт давсан +,тасарсан-	Хувь
ОРЛОГО	6,421.9	6,335.2	(86.70)	99%
ТАТВАРЫН ОРЛОГО	5,633.2	5,723.9	90.64	102%
Хувь хүний орлогын албан татвар	4,294.2	4,314.7	20.52	100%
Хувь хүний орлогын албан татвар	4,294.2	4,314.7	20.52	100%
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	4,410.1	4,396.2	(13.89)	100%
Үйл ажиллагааны орлого	206.1	203.0	(3.10)	98%
Хөрөнгө борлуулсны орлого	100.0	102.7	2.71	103%
Шууд бус орлого	98.0	130.0	32.02	133%
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(520.0)	(517.2)	2.77	99%
Өмчийн татвар	340.4	208.6	(131.77)	61%
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	279.8	175.2	(104.55)	63%
Бууны албан татвар	60.6	33.4	(27.22)	55%
Тусгай зориулалтын орлого	257.4	268.8	11.37	104%
МУ ын АТӨЯХАТ	257.4	268.8	11.37	104%
Бусад татвар / төлбөр хураамж /	741.2	931.8	190.52	126%
Улсын тэмдэгтийн хураамж	103.2	150.8	47.61	146%
Газрын төлбөр	207.0	210.2	3.22	102%
Ойн нөөц ашигласны төлбөр	1.3	1.4	0.15	111%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	88.7	107.5	18.75	121%
Ус,рашааны нөөц ашигласны төлбөр	77.7	208.0	130.30	268%
АМ-аас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	-	1.9	1.90	#DIV/0!
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	110.0	120.1	10.14	109%
Бусад татвар хураамж/ нохой/	0.2	0.8	0.65	425%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	153.2	131.0	(22.19)	86%
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	788.7	611.4	(177.34)	78%
Татварын бус орлого	767.9	602.8	(165.05)	79%
Хүү торгуулийн орлого	409.1	395.3	(13.81)	97%
Төсөвт өөрийн орлого	73.0	68.7	(4.27)	94%
Бусад орлого	279.6	123.9	(155.66)	44%
Түрээсийн орлого	6.3	14.9	8.69	239%
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	20.8	8.5	(12.29)	41%
Өмч хувьчлалын орлого	20.8	8.5	(12.29)	41%

- ✓ 10-ийн 100дээс дотоодын иргэдийн 90.3 % аорь 5,723.9 сая доллартай дадаагүй иргэдийнх, 9.7% аорь 611.4 сая доллартай дадаагүй аон иргэдийнх оон оон элдэв.
- ✓ 2016 онд нийт 11 нэр төрлийн орлогоор 273.5 сая төгрөгөөр давж биелсэн бол, 9 нэр төрлийн орлого 356.9 сая төгрөгөөр тасарсан дүнтэй байна. Орлогын дүнгээс давсан болон тасарсан орлогыг дараах хүснэгтээр харуулья.

2016 онд батлагдсан төлөвлөгөөнөөс давсан орлого / сая төгрөг/				
Орлогын нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлт давсан +,тасарсан-	Хувь
ОРЛОГО	955.9	1,229.4	273.5	129%
Шууд бус орлого	98.0	130.0	32.02	133%
МУ ын АТӨЯХАТ	257.4	268.8	11.37	104%
Улсын тэмдэгтийн хураамж	103.2	150.8	47.61	146%
Газрын төлбөр	207.0	210.2	3.22	102%
Ойн нөөц ашигласны төлбөр	1.3	1.4	0.15	111%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	88.7	107.5	18.75	121%
Ус,рашааны нөөц ашигласны төлбөр	77.7	208.0	130.30	268%
АМ-аас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	-	1.9	1.90	100%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	110.0	120.1	10.14	109%
Бусад татвар хураамж/ нохой/	0.2	0.8	0.65	425%
Түрээсийн орлого	6.3	14.9	8.69	239%

Давсан орлогууд:

Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл

- ❖ Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ус ашигласны төлбөр 130.3 сая төгрөгөөр давсан – “Тайшир Гуулин УЦС” ХХК-аас татварын урьд оны хяналт шалгалтын 37.6 сая төгрөг, урьд оны дутуу төлөлт 30.5 сая төгрөг төвлөрсөн. Мөн төлөвлөгөөнд тусгагдаагүй Ховд-Алтай чиглэлийн авто замд ашигласан усны төлбөрт 30.5 сая төгрөг, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй “Өү Жи Си Эйч Эйл” ХХК-аас 25.9 сая төгрөг тус тус төвлөрсөн нь уг орлого давахад нөлөөлсөн.
- ❖ Түрээсийн төлбөр 8.7 сая төгрөгөөр давсан – “Хүрийн овоо” ХХК Орон нутгийн өмчийн албаны өмчид бүртгэлтэй гражийг 2016.09.01-ээс эхлэн түрээслэж 6.8 сая төгрөгийн төлбөр төлсөн нь уг орлого давахад голлон нөлөөлсөн.

Сумдын төсвийн орлогын гүйцэтгэл

- ❖ Агнуурын нөөц ашигласны төлбөр 18.7 сая төгрөгөөр давсан –Алтай, Цогт, Жаргалан сумдад агналт хийгдсэн бөгөөд нийт орлогын 25 хувийг сумдад тодотгон зарцуулах эрх олгосон боловч Цогт, Жаргалан сум тайлант оны төсөвт тодотгол хийгээгүй учир төлөвлөгөө давсан байна.

2016 онд батлагдсан төлөвлөгөөнөөс тасарсан орлого / сая төгрөг/				
Орлогын нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлт давсан +, тасарсан-	Хувь
ОРЛОГО	5,892.27	5,535.30	(356.97)	94%
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	4,410.1	4,396.2	(13.89)	100%
Үйл ажиллагааны орлого	206.1	203.0	(3.10)	98%
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	279.8	175.2	(104.55)	63%
Бууны албан татвар	60.6	33.4	(27.22)	55%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	153.2	131.0	(22.19)	86%
Хүү торгуулийн орлого	409.1	395.3	(13.81)	97%
Төсөвт өөрийн орлого	73.0	68.7	(4.27)	94%
Бусад орлого	279.6	123.9	(155.66)	44%
Өмч хувьчлалын орлого	20.8	8.5	(12.29)	41%

Тасарсан орлогууд:

Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл

- ❖ Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 104.5 сая төгрөгөөр тасарсан - “Алтайн хүдэр” ХХК-аас 107.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч уг татвар төлөгдөөгүй өр үүссэн.
- ❖ Нэр заагдаж ангилагдаагүй бусад орлого 155.7 сая төгрөгөөр тасарсан – УИХ-ын гишүүний багцаас олгосон зээлийн эргэн төлөлтөөр 277.8 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан бөгөөд төлбөрийг барагдуулахаар ШШГА-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч эргэн төлөлт хангалтгүй байна.
- ❖ Өмч хувьчлалын орлого 12.3 сая төгрөгөөр тасарсан – Бугат сумын ЗДТГ-ын зочид буудлын барилга, Бугат сумын Цагдаагийн кабоны барилга, Хөхморьт сумын ЭМТ-ийн хуучин барилгыг хувьчлахаар төлөвлөсөн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.2.3-т заасны дагуу Төрийн өмчийн хороотой зөвшилцөхөөр санал хүргүүлсэн боловч Төрийн өмчийн хороо болон Орон нутгийн өмчийн албаны бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөс шалтгаалан хувьчлах хөрөнгийн жагсаалтад орж батлагдаагүй учраас төлөвлөсөн орлого тасарсан.

- ❖ Төсөвт байгууллагын өөрийн орлого 4.3 сая төгрөгөөр тасарсан – Худалдан авах ажиллагаа нь өөрийн орлогоор 10.0 сая төгрөг төвлөрүүлэхээр тооцсон боловч 4.1 сая төгрөг төвлөрүүлсэн нь уг орлогын төлөвлөгөө тасрахад голлон нөлөөлсөн.

Сумдын төсвийн орлогын гүйцэтгэл

- ❖ Галт зэвсгийн албан татвар 27.2 сая төгрөгөөр тасарсан –Дэлгэр, Хөхморьт, Есөнбулаг сумаас бусад сумын төлөвлөгөө тасарсан бөгөөд Цагдаагийн газрын бүртгэлд шилжилт хөдөлгөөн бүрэн хийгддэггүй, эзэмшигч нь давхардаж бүртгэгдсэн зэрэг зөрчилтэй байгаагаас шалтгаалсан байна.
- ❖ Хог хаягдлын үйлчилгээний хураамж 22.2 сая төгрөгөөр тасарсан – Бигэр, Тайшир, Цээл, Хөхморьт, Шарга сумаас бусад сумын төлөвлөгөө тасарсан бөгөөд сумын үйл ажиллагаанаас шалтгаалсан байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулсан судалгааг дараах графикаар харуулья.



Татварын болон татварын бус орлогын нийт төлөвлөгөөг Есөнбулаг сум 39.4 сая төгрөгөөр, Баянтоорой тосгон 2.8 сая төгрөгөөр, аймгийн төв 129.8 сая төгрөгөөр, нийт 172.0 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Өмнөх жилийн санхүүгийн аудитаас орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх тал дээр анхаарч ажиллах талаар албан шаардлага хүргүүлж байсан боловч энэ жилийн төсвийн орлогын нэр төрлийн гүйцэтгэлээс харахад шийдвэрийн биелэлт хангалтгүй байна. Орон нутгийн орлогын тасарсан шалтгаанаас үзэхэд орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөснөөс гадна татварын орлого оруулах эрх бүхий албан тушаалтны хариуцлагагүй ажилласантай холбоотой байна гэж үзлээ.

III Бүлэг. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн зарлага 91.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн 2016 оны тодотгосон төсөв батлах тухай Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 05-ны өдрийн 09 дугаар тогтоолоор аймгийн төсвийн нийт зарлагыг 54,473.9 сая ₮-аас 57,593.0 сая ₮-оор өсгөж, бөгөөд сумдын орон нутгийн болон, шилжих үлдэгдлээс санхүүжүүлэх төлөвлөгөөг нэмж нийт 57,593.0 сая төгрөгийн зардал гаргахаар баталж гүйцэтгэлээр 52,738.8 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Тайлант онд Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын дагуу төсөвт байгууллагууд аймгийн төрийн сангаас зөвшөөрөл авч гүйлгэн зарцуулалт хийгдээгүй байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2016 оны “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 07 дугаар тушаалын дагуу эдийн засгийн ангилалаар, бүлгийн дүнгээр авч үзвэл дараахь байдалтай байна. Хавсралт-8

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн 2016 йн төсвийн гүйцэтгэл

№	ЗАРДЛЫН БҮЛЭГ	2016				Нийт зардалд эзлэх хувь
		Өмнөх он	Төсөв	Тайлант он	хэмнэлт+, хэтрэлт-	
2101	Цалин хөлс нэмэгдэл урамшил	21,117.6	26,259.7	25,140.3	1,119.4	47.6 %
2102	Ажил олгогчоос төлөх НДШ	2,700.7	2,925.4	2,780.4	144.9	5.3 %
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,247.0	4,777.0	4,620.8	156.1	8.8 %
2104	Хангамж бараа материалын зардал	1,071.9	1,186.1	1,155.0	31.0	2.2 %
2105	Нормативт зардал	2,103.0	2,104.4	2,001.6	102.2	2.6 %
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	684.2	623.6	600.3	23.2	0.0 1%
2107	Томилолт, зочны зардал	274.6	305.3	281.9	23.3	0.5 %
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	264.3	1,319.0	1,145.0	174.0	2.2 %
2109	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	1,442.3	1,380.1	1,215.5	164.0	2.3 %
2131	Татаас, замын сан	188.3	14.0	14.0	0	0.02 %
2132	Урсгал шилжүүлэг	6,147.4	6,905.6	6,518.4	387.2	12.3 %
220	Хөрөнгийн зардал	8,925.6	7,980.2	6,445.9	1,534.2	12.2 %
23	Эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	1,812.1	819.1	993.0	1.5%
	Дүн	57,954.5	57,593.0	52,738.8	4,854.2	100.0

Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллаар гаргаж дараах хүснэгтээр харуулж байна.

сая төгрөг

Дугаар	Хөтөлбөр, ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
70105	ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	1,186.6	1,158.2	28.4	97.6%
70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдах байгууллага	9,782.9	9,342.6	440.3	95.5%
70416	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн	3.0	1.7	1.3	56.6%
70417	Мэргэжлийн хяналт	88.3	87.0	1.3	98.5%
70418	Худалдан авах ажиллагаа	44.6	41.4	3.2	92.8%
70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	89.1	79.3	9.7	89%
70503	Орон нутгийн зорилтот ХОруулалт	6,177.7	4,733.0	1,444.7	76.6%
70709	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	59.1	56.2	2.9	95%
70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	52.9	3.0	49.9	5.6%
70802	Газар тариалан хөгжүүлэх	16.5	1.6	14.8	9.6%
71105	Авто тээврийн хяналт, зохицуул	14.0	14.0	0	100%
71403	Ойжуулалт	49.2	48.9	0.3	99.4%
71411	Хирээлэн буй орчны бодлого, удирдлага	482.1	446.3	35.7	92.5%
71502	Хот байгуулалт, тохижилт	358.6	344.2	14.4	95.9%
71504	Газрын зураглал, кадастр	183.9	177.2	6.7	96.3%
71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	4,382.9	4,301.2	81.7	98.1%
71701	Биеийн тамир спорт	470.0	466.8	3.2	99.3%
71702	Соёл урлаг	2,435.1	2,400.4	34.7	98.5%
71801	Сургуулийн өмнөх боловсрол	6,119.3	5,877.5	241.8	96.0%
71802	Ерөнхий боловсрол	18,281.3	17,186.0	1,095.3	94%
71806	Насан туршын болон албан бус боловсрол	94.0	78.5	15.5	83.5%
71902	Нийгмийн халамж	5,013.3	4,725.3	288.0	94.2%
72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	1,812.1	819.1	993.0	45.2%
72207	Хүүхдийн хөгжил, хамгаалал	336.9	291.3	45.6	86.4%
72208	Ахмад насны хөгжил хамгаалал	59.0	58.0	1.0	98.3%
Дүн		57,593.0	52,738.8	4,854.2	

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2016 оны төсвийг 25 хөтөлбөрөөр төлөвлөж, гүйцэтгэлийг харьцуулан гаргалаа. Хамгийн бага гүйцэтгэлтэй “Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр” 5.6 хувьтай байхад Нийгмийн эрүүл мэнд, авто тээврийн хяналт зохицуулалтын хөтөлбөр 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн санхүүжилт, Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн талаар

Орон нутгийн ОАҢ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байгууллагуудын хувьд 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймаг, сумдын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төрийн санд сар бүр хүсэлт баталгааны маягтыг гарган өгч, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагуудын төсвийн төлөвлөгөө гүйцэтгэлийг нэг бүрчлэн тооцоход бүлгийн дүнгээр 25.8 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3 /Төрийн сан төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх үүрэгтэй/ гэж заасны дагуу төрийн сангийн чиг үүрэг хэрэгжихгүй байгааг харуулж байна.

“Сангийн сайдын 2014 оны 05 дугаар тушаалын 06 дугаар хавсралтын дагуу төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг баримтлан ажиллаагүйгээс төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэл төсвийн хэлбэлзлээс 28.9 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Цаашид Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам түүнтэй холбогдон гарсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар урсгал зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зардлын данстай холбоотой нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам, заавар мөрдөөгүй, дансны бичилт буруу хийсэн, төсвийг зориулалт бусаар, үрэлгэн, үр ашиггүй зарцуулсан зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

Цалин, хангамж, томилолт, эд хогшил, нийгмийн хамгаалал, зочны болон нормативт зардлуудыг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- ✚ Цалингийн урьдчилгааг суутгаагүй, цалин хөлс, үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон, анхан шатны нотлох баримтгүйгээр албан томилолт, унаа, байр хоолны зардлыг олгосон, тэтгэмжийг үндэслэлгүйгээр олгосон зэрэг 147.5 сая төгрөгийн зөрчил илэрснийг байгууллагуудаар нь авч үзвэл Алтай, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тонхил, Төгрөг, Хөхморьт, Есөнбулаг сумдын нэгж байгууллагуудын зөрчил эзэлж байна.

- ✚ УИХ-ын 2016 оны 47-р тогтоолыг зөрчиж албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлсэн 3.5 сая төгрөгийн, тавилга эд хогшил бэлтгэсэн 9.8 сая төгрөгийн зөрчил илэрснийг Дэлгэр, Тонхил, Цогт сум, Есөнбулаг сумын болон Баянтоорой тосгоны төсөвт байгууллагуудын зөрчил эзэлж байна.
- ✚ Ажилчдын цалинг Нийгмийн даатгалд зөрүүтэй тайлагнасан, цалингаас НДШ, ХХОАТ дутуу суутгасан зэрэг нийт 35.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- ✚ Батлагдсан орон тооноос илүү ажиллуулсан 14.5 сая төгрөгийн зөрчил аймгийн ЗДТГ-т илэрсэн.
- ✚ Төрийн сангийн тамга тэмдэг дарж баталгаажуулаагүй гүйлгээ хийсэн 154.2 сая төгрөгийн зөрчил илэрснийг Дэлгэр сумын Гуулин тосгоны төсөвт байгууллагууд эзэлж байна.
- ✚ Анхан шатны баримтгүйгээр, баримтын бүрдэл дутуугаар зардал гаргасан 218.8 сая төгрөгийн зөрчил Алтай, Дарив, Дэлгэр, Халиун, Эрдэнэ, Есөнбулаг сум, Гуулин, Баянтоорой тосгоны болон аймгийн төвийн төсөвт байгууллагуудаас илэрсэн.
- ✚ Жолоочийн шатахууны тооцоог бодоогүй, шатахууны зардлыг юунд зарцуулсан нь тодорхойгүй анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, замын хуудасгүйгээр зарцуулсан 80.9 сая төгрөгийн зөрчлийг Дарив, Төгрөг, Халиун, Эрдэнэ, Есөнбулаг сумын болон аймгийн төсөвт байгууллагуудад илэрсэн.
- ✚ Удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон 150.3 сая төгрөгийн зөрчил Дэлгэр, Жаргалан, Халиун, Чандмань, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг сумын болон аймгийн төвийн төсөвт байгууллагуудад илэрсэн гэх мэт зөрчлүүд илэрсэн.

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР:

Тайлант онд орон нутгийн салбарын байгууллагууд 1,147.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн судалгаа

Салбарын ангилал	Авсан нэмэлт санхүүжилт /сая/төг/
Орон нутгийн төсвийн байгууллагууд	521.7
Боловсрол Соёл Шинжлэх ухааны сайд	119.3
Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайд	126.6
Эрүүл мэндийн сайд	213.6
Барилга хот байгуулалтын сайд	166.7
Дүн	1,147.9

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд нь **32,237.0** сая төгрөгийн санхүүжилт, **66.0** сая төгрөгийн өөрийн орлогын төлөвлөгөөтэй ба гүйцэтгэлээр бүрэн санхүүжигдэж үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогоор **108.4** сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэлээр **30,821.8** сая төгрөгийг зарцуулсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл
/Сая.төгрөг/

д/д	Салбар	Тусгай зориулалтын шилжүүлэг		Өөрийн орлого		Нэгдсэн тайлангаарх төлөвлөгөө	Нэгдсэн тайлангаарх гүйцэтгэл	Хэтрэлт+хэмнэлт-
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл			
1	БСШУ-ны сайд	27,333.2	25,897.9	66.6	65.5	27,399.8	25,963.4	1,436.4
2	БХБ-ын сайд	183.9	177.1	0	42.8	183.9	219.9	-36
3	ХАХНХ-ийн сайд	336.9	336.9	0	0	336.9	336.9	0
4	ЭМ-ийн сайд	4,382.9	4,301.5		0.18	4,382.9	4,301.68	81.22
	Дүн	32,237.0	30,713.4	66.6	108.48	32,303.5	30,821.88	1,481.62

Төсвийн гүйцэтгэл 95.4 хувьтай буюу **30,821.8** сая төгрөг байгаа нь Барилга хот байгуулалтын сайдын багцаас 121.6 сая төгрөг, БСШУ-ын сайдын багцаас 1,394.8 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын багцаас 82.0 сая төгрөг нийт 1,598.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн төсвийн үр дүнгийн үзүүлэлт:

Аймгийн болон сумдын нийт орон нутгийн 2016 оны төсвийн урсгал тэнцлийг 45,066.9 сая төгрөг, нийт тэнцлийг 1,944.9 сая төгрөгийн алдагдалтай байхаар баталсан боловч гүйцэтгэлээр урсгал тэнцэл 43,081.1 сая төгрөгийн алдагдалтай, нийт тэнцэл 1,205.6 сая төгрөгийн ашигтай гарсан байна.

Орон нутгийн нэгдсэн төсвийн тэнцэл / сая.төгрөг/

Үзүүлэлт

2016 он

	Батлагдсан Төсөв	Гүйцэтгэл
Нийт орлого ба тусламжийн дүн	55,648.1	53,944.4
Урсгал орлого	6,348.4	6,335.2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	57,593.0	52,738.8
Урсгал зардал	47,800.6	45,473.7
Урсгал тэнцэл	(41,452.2)	(43,081.1)
Нийт тэнцэл	(1,944.9)	1,205.6

ИЛРҮҮЛЭЛТ:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар жижиг дунд үйлдвэрлэл, эрчимжсэн газар тариалан, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйг дэмжих зорилгоор хоршоо, иргэдэд олгосон зээлээс эргэн төлөгдөх хугацаа дууссан боловч одоогийн байдлаар 62 иргэн, аж ахуйн нэгж, хоршоотой холбоотой 751.4 сая төгрөгийн зээлийг төлүүлээгүй нь бусад орлогын төлөвлөгөө тасрах үндсэн шалтгаан болсон.
2. АУЭХС ТӨХК нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоос 25%-ийг ажлын хөлс болгон 17.4 сая төгрөгийг хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоос суутган тооцсоноор орлого тасрах үндэслэл болсон.
3. Бууны албан татварын хувьд галт зэвсэг эзэмшигч нь харьяа цагдаагийн байгууллагад анх бүртгүүлэх, шилжилт хөдөлгөөнийг хийлгэх хасуулах харилцааг бүртгүүлэхээр байгаа хэдий ч энэ процесс хийгдэхгүй, иргэдийн гар дээр байгаа галт зэвсгийн мэдээлэл бодитой байхгүйгээс болж төлөвлөлтийг үндэслэлгүй төлөвлөж байна.
4. Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувьд “Алтайн хүдэр”ХХК 2015 онд 102.0 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн албан татварыг төлөөгүйгээс орлого тасарсан бол 2016 онд мөн 107.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг тасалсан байна.
5. Судалгаагаар цалин, НДШ-ийн зардлыг 1,264.3 сая төгрөгөөр, тогтмол зардлыг нийт 151.2 сая төгрөгөөр, хоол үдийн цайны зардлыг 125.8 сая төгрөгөөр хэмнэсэн нь бодит бус хэмнэлт байна.
6. Боловсролын салбарын багш нарын цалингийн зардлыг төлөвлөхдөө нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативыг баримтлаагүй.
7. Орон нутгийн төсвийн орлого нийт дүнгээрээ 86.7 сая төгрөгөөр тасалсан боловч 9 нэр төрлийн орлого 356.9 сая төгрөгөөр тасарсан байна.

ДҮГНЭЛТ

Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаас дараах дүгнэлтийг хүргүүлж байна.

1. Орон нутгийн орлого, төсөвт байгууллагуудын төсвийн төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөн, орлого зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж ажиллах шаардлагатай байна.
2. “Боловсролын салбарын төсвийн төлөвлөлтийг үнэн зөв оновчтой хийхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативыг баримтлан боловсролын салбарт хүлээгдэж буй хууль дүрэм журмын хэрэгжилтийг хангахаар байна.
3. Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам түүнтэй холбогдон гарсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах шаардлага бий болжээ.

Дээрх дүгнэлтэнд үндэслээд дараах шийдвэрийг гаргаж байна.

Зөвлөмж

ТЕЗ, аймгийн Засаг дарга С.Гансэлэмд:

1. Орон нутгийн орлого төлөвлөлттэй холбоотой хэлтэс, агентлагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан, төсвийн төлөвлөлтийг бодит тоон судалгаанд үндэслэн төлөвлөж, татварын бааз суурийг бодитой тодорхойлон, гүйцэтгэлийг хангаж ажиллах

Есөнбулаг сумын Засаг дарга Ш.Дагвад

1. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг гэрээний дагуу бүрэн төвлөрүүлж, АУЭХС ТӨХК-д олгох ажлын хөлсийг урсгал зардалд төлөвлөн олгож байх

Албан шаардлага

ТЕЗ, аймгийн Засаг дарга С.Гансэлэмд:

1. Хоршоо иргэдэд олгосон зээлийг эргэн төлүүлэх үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР